



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 22 өдөр

Дугаар А/316

Чингис хот

Х.Болортуяад дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6-ын "г", Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2.2, 40.2.4, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2, 58.2.20, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэрлэн сумын 2 дугаар багийн иргэн Х.Болортуяагийн өргөдлийн дагуу эмчилгээний зардалд 500.000 /таван зуун мянган/ төгрөгийн буцалтгүй тусламж олгосугай.

2. Буцалтгүй тусламжид шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн байгууллага, иргэдээс тавьсан хүсэлтийг шийдвэрлэх зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА